

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН 2024 ОНЫ  
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТЭД  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

2024.06.21

Дархан-Уул

**Нэг. Хяналт-шинжилгээний зорилго**

Дархан-Уул аймгийн Соёл, урлагийн газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн биелэлтэд хяналт-шинжилгээ хийж, гүйцэтгэлийн тавьсан зорилт, хүрэх түвшинтэй нь харьцуулан хэрэгжилтийн үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хариуцлагыг сайжруулах, дүгнэлт, зөвлөмж гаргах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах зорилготой.

**Хоёр. Хяналт-шинжилгээ хийх үндэслэл**

Хяналт- шинжилгээг Монгол улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол, Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох тайлан гаргах журам” -ын 4.2 дэх заалтаар хуульчлан зохицуулсны дагуу тус газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн биелэлтийн тайланг үндэслэл болгон хяналт-шинжилгээ хийж гүйцэтгэв.

**Гурав. Хяналт-шинжилгээний ажлын үр дүн**

Тус газар нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан, хэрэгжилтийн үр дүнг эхний хагас жилийн байдлаар тайлагнан ажилласан. Төлөвлөгөөний биелэлтийг хянаж үзэхэд: 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 19 зорилтын хүрээнд 83 арга хэмжээг тусган тоо хэмжээ, чанарын шалгуур үзүүлэлтээр гарган тайлагнахаар үйл ажиллагааг зохион байгуулж ажилласан байна.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн биелэлтийн үнэлгээ:

№	Хэрэгжилтийн хувь	Арга хэмжээний тоо -83
1	“Үр дүнтэй” буюу 100 хувьтай	75
2	“Тодорхой үр дүнд хүрсэн” буюу 90 хувьтай	2
4	“Тодорхой үр дүнд хүрсэн” буюу 70 хувьтай	6
<b>Нийт үнэлгээний хувь – 97.95%</b>		

**Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээг  
зорилт тус бүрээр харуулвал**

№	Дэвшүүлсэн зорилтууд	Арга хэмжээн ий тоо	Зорилтын хэрэгжилт ( хувиар )			
			Үр дүнтэй (100%)	Тодорхой үр дүнд хүрсэн (70-99%)	Эрчимжү үлэх шаардла гатай (31-69%)	Үр дүнгүй (0-30%)
1	1.1 Соёлын салбарын бодлого, хөгжлийн хэтийн чиглэлийг судалгаа шинжилгээнд тулгуурлан тодорхойлж, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно	2	100			
2	1.2. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлсийн хадгалалт, хамгаалалт, гадна өнгө төрх, сэргээн засварлалтын ажлыг сайжруулна.	5		94		
3	1.3.Түүх, соёлын дурсгалын үзмэр, баяжилтыг нэмэгдүүлж, хадгалалт, хамгаалалтыг сайжруулна.	4		92.5		
4	1.4. Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдыг нээн илрүүлэх, түгээн дэлгэрүүлэх, сурталчлах үйл ажиллагааг бүх шатанд эрчимжүүлнэ.	2	100			
5	1.5.Соёл, урлагийн байгууллагуудын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.	6	100			
6	1.6. Сумдын соёлын төвийн үзвэр, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.	3	100			
7	1.7. Уламжлалт баяр наадам, задгай талбайн тоглолт /эвент/ арга хэмжээний чанар, хүртээмжийг сайжруулна.	3		90		
8	1.8.Утга зохиол, ном хэвлэлийн зохион туурвигчдын бүтээн туурвих үйл ажиллагааг дэмжинэ.	4	100			
9	1.9. Бүх шатны номын сангийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлнэ.	2	100			
10	1.10. Иргэдийг угийн бичиг хөтлөх арга зүйгээр хангах, ач холбогдлын талаар хүүхэд залуучуудад бага наснаас нь ойлголт, хандлага бий болгоно.	2	100			
11	1.11. Монгол хэл, бичгээ үндэсний үнэт зүйлийн бүрдэл болгон иргэн бүр чанартай эзэмшиж хэрэглэнэ.	2	90			

12	1.12. Бүх нийтийн соёлын боловсролыг дээшлүүлэх, үндэсний соёлын дархлааг нэмэгдүүлнэ.	7		95.7		
13	3.1. Дүрслэх урлагийн бүтээл гаргах, олон нийтэд толилуулах, зохиогчийн эрхийн зөвшөөрөл авахад дэмжлэг үзүүлнэ.	3	100			
14	3.2. Орон нутгийн телевиз, радиогийн уран сайхны нийтлэл нэвтрүүлгийн бодлого үйл ажиллагааг дэмжинэ.	4	100			
15	3.3. Кино үзвэр үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.	2	100			
16	4.1. Байгууллагын тайлагнах үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлнэ.	14		97.8		
17	4.2. Хүний нөөцийн сургалт, нийгмийн асуудлыг шийдвэрлэнэ.	7	100			
18	4.3. Санхүүгийн удирдлага, төлөвлөлт, гүйцэтгэлд тавих хяналтыг чангатгаж, үр дүнг тайлагнах, шилэн дансны бүртгэлийн хөтлөлт, үнэн зөв байдлыг хангана.	8	100			
19	4.4. Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын ажлыг сайжруулна.	3	100			
<b>НИЙТ ҮНЭЛГЭЭ 97.95%</b>						

### **ДӨРӨВ. ДҮГНЭЛТ**

Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн биелэлтэд хяналт-шинжилгээ хийж гүйцэтгэхэд:

1. 100 хувийн буюу “Үр дүнтэй” – 76 арга хэмжээ
2. 90 хувийн буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” – 2 арга хэмжээ
3. 70 хувийн буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” - 5 арга хэмжээ

Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн биелэлтийн тайланд хяналт шинжилгээ хийж 97.95 хувьтай үнэлэгдлээ .

70 хувь үнэлэгдсэн 6 арга хэмжээг авч үзвэл:

1.2.5. Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллого хийхэд дэмжлэг үзүүлнэ.

Хүрсэн түвшин: Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн Улсын тооллогыг зохион байгуулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын захирамжаар байгуулсан. Хонгор, Орхон сумдын соёлын төвийн Музейн сан хөмрөгт хадгалагдаж буй үзмэрийн бүртгэл, тооллогод хяналт тавьж арга зүйн зөвлөгөө өгөв. Бүртгэл тооллогод Хонгор сум 115 дэсийн 120, Орхон сум 28 дэсийн 31 үзмэрийг хамруулав. Тооллого зохион

байгуулах урьдчилсан бэлтгэл хангагдсан. /2024 оны 9 дүгээр сараас тооллого эхлэнэ/

1.3.1.Музейн сан хөмрөгийг баяжуулж, үзмэрүүдийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

Хүрсэн түвшин: Орхон сумын Соёлын төвийн Музей хандиваар 5 үзмэрийн баяжилт хийгдсэн. Ингэснээр тус сумын музей нь нийт 36 үзмэртэй болсон.

1.7.1.Үндэсний баяр наадмын соёл, урлагийн арга хэмжээний хүрээнд "Дээлтэй Монгол наадам", "Монголын сайхан орон" дүрслэх урлагийн үзэсгэлэн, "Монгол бахархал" гэрэл зургийн үзэсгэлэн арга хэмжээг зохион байгуулна.

Хүрсэн түвшин: Тайлант хугацаанд 2 арга хэмжээг зохион байгуулсан. Ирэх 7 дугаар сард зохион байгуулах 3 арга хэмжээний төлөвлөгөө, төсвийн төслийг боловсруулсан. /Баяр наадмын үеэр 7-р сард зохион байгуулагдана/

1.12.7."Соёлын сэргэлт-2024" арга хэмжээг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж оролцох

Хүрсэн түвшин: Төвийн бүсийн "Соёлын сэргэлт-2024" аяны хүрээнд зохион байгуулах 20 арга хэмжээ бүхий нэгдсэн хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулсан. Ажлын хэсгийн 8 удаагийн цахим хуралд оролцож "Соёлын сэргэлт 2024" нэгдсэн зөвлөгөөнд тус аймгийн 7 байгууллагын 10 удирдлага оролцсон. / Арга хэмжээ 9-р сард зохион байгуулагдана/

4.1.3.Байгууллагын ёс зүйн дэд хороог байгуулах, төлөвлөгөө боловсруулж батлуулах, хэрэгжилтийг хангуулах, ёс зүйн зөрчлийн мэдээг хагас, бүтэн жилээр хугацаанд нь тайлагнана.

Хүрсэн түвшин: Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд нийцүүлэн тус газрын хамт олны хурлаар байгууллагын дэргэдэх орон тооны бус Ёс зүйн дэд хороог 3 хүний бүрэлдэхүүнтэйгээр 5 жилийн хугацаатайгаар сонгож, газрын даргын 2024 оны А/04 дүгээр тушаалаар байгуулсан. Ёс зүйн 2 сургалтад хамрагдсан. Тайлант хугацаанд тус газрын албан хаагчид ёсзүйн зөрчилгүй ажилласан болно хэмээн тайлагнасан байна.

#### **Онцлох ажлууд:**

##### Хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрийн чиглэлээр:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар сангийн яамаас тус аймагт эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн 500.0 сая төгрөгийн үнэ бүхий 6 нэр төрлийн 13 ширхэг техник, тоног төхөөрөмжүүдийг соёлын байгууллагуудад хуваарилан өгсөн.

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Соёлын яамнаас Дархан-Уул аймагт эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн 300.0 сая төгрөгийн үнэ бүхий соёлын салбарын төрийн үйлчилгээний техник, тоног төхөөрөмж шинэчлэх төслийн худалдан авах ажиллагааны үр дүн гарч "Хос-Анар" ХХК шалгарсан. Уг төслийн хүрээнд соёлын байгууллагуудын тус бүрийн онцлогт тохирсон 23 нэр төрлийн 97 ширхэг техник, тоног төхөөрөмжийг 2023 онд авсан судалгаанд үндэслэн соёлын байгууллагуудад хуваарилан өгсөн.
- 2024 оны 5 дугаар сард улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн Дархан-Уул аймгийн Соёлын байгууллагуудад хэрэгцээтэй тоног төхөөрөмж буюу 44.5 сая төгрөгийн үнэ бүхий 23 нэр төрлийн 42 ширхэг хөгжмийн зэмсгүүдийг хүлээн авсан.
- Тайлант хугацаанд тус аймгийн соёлын салбарт 4 удаагийн төсөл хөтөлбөрөөр нийт 859.5 сая төгрөгийн энэ бүхий 49 нэр төрлийн 156 ширхэг техник, тоног төхөөрөмжөөр шинэчлэл хийсэн байна.

#### Соёлын өвийн чиглэлээр:

- 2024 оны 06 дугаар сарын 11-ний өдөр Музейн үзүүллэг дэглэлт, үзэл баримтлалыг боловсруулан СУИС-ийн багш, Доктор (Ph.D.) Мяндал, доктор (Ph.D.) О.Ангарагсүрэн нараар ахлуулсан ажлын хэсэг болон аймгийн төлөөлөл хуралдаж хүлээлгэж өгөв.
- Соёлын өвийг хамгаалах тухай 2003 оны ЮНЕСКО-ийн Соёлын биет бус өвийн төлөөллийн жагсаалтад бүртгэгдсэн "Монгол гээийн уламжлалт урлал, зан үйл" өвийг түгээн дэлгэрүүлэх, Монголын өв уламжлал, соёлын үнэт зүйлсийг сурталчлан таниулах, үр хойчдоо өвлүүлэх зорилготой "Гэр" үзэсгэлэнгийн хүрээнд Дарханы Зураач, урчуудын эвлэлийн гишүүн, MOZU брэндийг үүсгэн байгуулагч 2 зураачтай монгол зургаар чимэглэсэн халх монгол гэрийг бүтээх, урлах 30,370,000 төгрөгийн төслийг гэрээ байгуулж хамтран ажилласан.
- Соёл, урлагийн газар Найрамдлын Дархан өргөөтэй болсон. Тус гэрээр дамжуулан "Монгол гэр хэрхэн үүсэж хөгжсөн түүх", "Оюуны цэнгэл" уламжлалт наадгай, "Хөөрхөн Нада" хөлөгт наадгай, "Аман яруу найраг-оньсого", "Нада-тай цуг Найрамдлын Музейгээр аялая" зурагт комик, "Хорол, үйчүүр наадгай" хөтөлбөрийг зохион байгуулж 17,706 иргэдэд үйлчилсэн. Монгол гэрийн уламжлалт ахуй, өв соёлыг таниулах хөтөлбөрийг зохион байгуулах боломж бүрдсэн.

- ЮНЕСКО, Соёлын яамны дэмжлэгтэйгээр СУИС-ийн Соёлын сургуулиас хэрэгжүүлж буй “Монгол бий биелгээг өвлүүлэн уламжлуулж, оршин тогтнох чадварыг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд “Бий биелгээний шавь сургалтын танхим”-ыг Хүүхдийн номын ордныг түшиглэн тус танхимыг нээсэн.
- Дархан-Уул аймгийн хэмжээнд 84 өвлөн уламжлагч [www.ich.mongoluv.mn](http://www.ich.mongoluv.mn) улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд бүртгэлтэй байдаг ба үүнээс МУ-аас ЮНЕСКО-ийн жагсаалтад орсон Морин хуур, Монгол Ардын уртын дуу, Монгол бий биелгээ, Монголын Уламжлалт Хөөмийн урлаг, Монгол уран бичлэг зэрэг өвийг өвлөсөн Дархан, Шарын гол, Орхон, Хонгор сумын харьяат 29 өвлөн уламжлагчид БАТЛАМЖ гардуулж ЮНЕСКО-ийн яаралтай болон төлөөллийн жагсаалтад бүртгэгдсэн өвийг өвлөн уламжилж, хойч үедээ түгээн дэлгэрүүлэх, өвлүүлэн үлдээх үүргээ биелүүлж буйд Талархал илэрхийлэв.
- Монгол Улсын Ерөнхий Сайдын “2024 оны эхний хагас жилд хэрэгжилтийг эрчимжүүлэх төсөл, арга хэмжээний тухай” 01 дүгээр албан даалгаврын хүрээнд “Дархан тайж хасарын нэрэмжит төвийн бүсийн аварга шалгаруулах монгол нохойн үзэсгэлэн, тэмцээн”, Чингис мастер кросс” эвэнт, “Монгол гэр” үзэсгэлэн зэрэг нийт томоохон 3 арга хэмжээг зохион байгуулсан.

Урлаг, уран бүтээлийн чиглэлээр:

- Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр соёлын байгууллагууд 19 хөтөлбөрийг зохион байгуулж нийт 5000 гаруй хүүхэд, иргэдэд хүргэлээ. Тус өдрийн үйл ажиллагаанд зохион байгуулах зардалд аймгийн ЗДТГ-ын даргын 2024 оны 02-А/109 тушаалаар 36.869.300 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.
- Залуучууд театр нь Самуил Яковлевич Маршакийн зохиол, МУСТА Н.Баярцэнгэлийн найруулга “Муурын байшин” хүүхдийн драмын жүжгийг шинээр найруулан тавьж нийт 23 удаа тоглож 6800 хүүхдэд хүргэлээ. Тус уран бүтээлд 22,2 сая төгрөг зарцуулж 34,6 сая төгрөгийн орлого төвлөрүүлээд байна.
- 2024 оны 06 дугаар сарын 9-14-ний өдрүүдэд ЮНЕСКО-ийн Театр Урлагийн Институтийн Косово дахь салбар “МоноАкт” аас зохион байгуулах Олон улсын нэг хүний жүжгийн 16 дэх уралдаант фестивальд тус аймгийн Залуучууд театрын жүжигчин Ч.Дунгаамаа “Хайрт минь, энэ зөвхөн эхлэл нь” жүжгээр оролцох зардалд аймгийн ЗДТГ-ын даргын 2024 оны 02-А/114 дүгээр тушаалаар 1.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.

- Залуучууд театр нь соёлын үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд явуулын орон зай буюу зөөврийн тайзтай болсон.

Соёл гэгээрлийн чиглэлээр:

- "Үндэсний бичиг соёл, номын өдрүүд 2024" хаврын номын баярыг "Илүү их уншъя" уриан дор 5 дугаар сарын 18-наас 5 дугаар сарын 30-ны хугацаанд нийт 13 өдөр номоор дамжуулан иргэдийг соён гэгээрүүлэх олон талт үйл ажиллагааг зохион байгуулж өнгөрүүлэв. Үүнд: Төв номын сан 26 арга хэмжээг 59 удаа зохион байгуулж 11,347 хүн хамруулсан байна.
- Тус аймгаас "Хаврын номын баяр"-ын хүрээнд зарласан "Номын сайн нөхөр" улсын уралдаанд ЕБС-ийн сургуулийн 6 анги, уншигчийн материалыг хүргүүлж ажилласан. Уралдаанд "Од" цогцолбор сургуулийн 5-10 ангийн хамт олон "Улсын Тэргүүний шилдэг уншигч хамт олон"-оор шалгарч 2024.05.28-ны өдөр Улаанбаатар хотноо "35 дахь Номын баяр"-ын нээлтийн үеэр УИХ-ын дарга Г.Занданшатарас шагналаа гардан авсан. Мөн аймгийн Засаг даргаас тус анги, хамт олныг "Олон улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр" шагнаж урамшууллаа.
- "Дарханы түүх, соёл, эрт эдүгээ" эрдэм шинжилгээний хурлыг 2024.04.12-ны өдөр зохион байгуулж, 120 хүнийг хамруулсан. Тус хуралд 14 эрдэмтэн, академич, доктор, профессор, судлаачид оролцож бүтээн байгуулалтын үеийн Дархан хот, археологийн судалгааны үр дүн, түүх, соёлын архивын баримтууд, угсаатны зүйн судалгаа, Музейн үзэл баримтлал зэрэг сэдвээр илтгэл тавьж хэлэлцүүлэв. Бага хурлыг зохион байгуулах зардалд аймгийн ЗДТГ-ын даргын 2024 оны 02-А/58 дугаар захирамжаар 2.0 сая төгрөг, Дархан сумын ЗДТГ-аас 2.0 сая төгрөгийн дэмжлэгийг тус тус үзүүлсэн.
- "Хос бичигтэн-2025" эрдэм шинжилгээний хурлыг 2024.05.24-ний өдөр зохион байгуулж, монгол хэл бичгийн эрдэмтэн багш, номын санчид зэрэг нийт 62 хүн оролцов. Тус хурлыг зохион байгуулах зардалд аймгийн ЗДТГ-аас 2,265,000 төгрөгийг шийдвэрлэсэн.
- Соёл, урлагийн газар болон соёлын 7 байгууллага албаны үйл ажиллагаандаа Монгол бичгийн цахим сурах бичиг, толь бичиг, хөрвүүлэх программыг нэвтрүүлсэн. Тайлант хугацаанд дээрх байгууллагууд нийт 62 албан бичгийг хос бичгээр үйлдсэн.
- Төв номын сан нь "Харааны бэрхшээлтэй уншигчдад номын сангийн үйлчилгээ үзүүлэх соёлын хүртээмжийг нэмэгдүүлэх нь" 60,0 сая төгрөгийн төслийн худалдан авалт зарласан. Үр дүн хүлээгдэж байна. Ингэснээр тус

аймгийн хөгжлийн бэрхшээлтэй 4578 иргэн буюу 4,7% нь соёлын үйлчилгээг авах боломж бүрдсэн байна.

#### САНАЛ ЗӨВЛӨМЖ

- Харьяа байгууллагуудын тайланг хүлээн авахдаа арга хэмжээ тус бүрээр нотлох баримт хавсралтаар ирүүлэхэд анхаарах
- Арга хэмжээ тус бүрийг тайлагнахдаа 2000 тэмдэгтэд багтаах
- Арга хэмжээ тус бүрийн хүрсэн түвшинг нэгтгэн тоо болон хувиар илэрхийлэн дүгнэж бичих
- 70 хувь үнэлэгдсэн 5 арга хэмжээг эрчимжүүлэн ажиллах

ТАНИЛЦСАН

СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН ДАРГА:



Х.СОЁЛ-ЭРДЭНЭ

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ТАЙЛАН БИЧСЭН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, СТАТИСТИК МЭДЭЭ

ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Ш.ДЭЛГЭРМАА



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН  
2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН

2024.06.12

Дархан-уул аймаг

№	Стратегийн зорилтууд	Хэрэгжилтийн хувь	Оноо
<b>Зорилт-1</b>			
1	Стратегийн зорилт 1.1	100.0	5.0
2	Стратегийн зорилт 1.2	94.0	4.7
3	Стратегийн зорилт 1.3	93.0	4.65
4	Стратегийн зорилт 1.4	100.0	5.0
5	Стратегийн зорилт 1.5	100.0	5.0
6	Стратегийн зорилт 1.6	100.0	5.0
7	Стратегийн зорилт 1.7	90.0	4.5
8	Стратегийн зорилт 1.8	100.0	5.0
9	Стратегийн зорилт 1.9	100.0	5.0
10	Стратегийн зорилт 1.10	100.0	5.0
11	Стратегийн зорилт 1.11	90.0	4.5
12	Стратегийн зорилт 1.12	96.0	4.8
<b>Зорилт 1-ийн дүн</b>			
<b>Зорилт-3</b>			
13	Стратегийн зорилт 3.1	100.0	5.0
14	Стратегийн зорилт 3.2	100.0	5.0
15	Стратегийн зорилт 3.3	100.0	5.0
<b>Зорилт 3-ын дүн</b>			
<b>Зорилт-4</b>			
16	Стратегийн зорилт 4.1	100.0	5.0
17	Стратегийн зорилт 4.2	100.0	5.0
18	Стратегийн зорилт 4.3	100.0	5.0
19	Стратегийн зорилт 4.4	100.0	5.0
<b>Зорилт 4-ийн дүн</b>			5.0
<b>ЕРӨНХИЙ ДҮН</b>		<b>98.0</b>	<b>4.9</b>

ТАНИЛЦСАН:  
ГАЗРЫН ДАРГА

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН:  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, СТАТИСТИК  
МЭДЭЭ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН



Х.СОЁЛ-ЭРДЭНЭ

Ш.ДЭЛГЭРМАА